
**МТ-ийн засаглал —
МТ-ийн засаглалын
зарчимд суурилсан стандартын арга зүй**

Агуулга

Өмнөх үг.....	3
Танилцуулга.....	4
1 Хамрах хүрээ	5
3 Нэр томъёо, тодорхойлолт.....	5
4 МТ-ийн засаглалын стандарт	5
4.1 МТ-ийн засаглалын стандартын зорилго, чиглэл	5
4.2 МТ-ийн засаглалын стандартын ерөнхий зөвлөмж.....	6
5 МТ-ийн засаглалын зарчимд суурилсан арга зүй.....	6
5.1 Зарчимд суурилсан стандартыг ашиглах.....	6
5.2 Засаглалын тогтолцоо.....	6
5.3 Зармуудын багц	7
5.4 Зарчмын хэрэгжилт ба бизнесийн үр дүнгийн хоорондын хамаарал	7
6 Засаглалын зарчим бүрт шаардлагатай мэдээлэл	8
6.1 Мэдээллийн бүрдэлүүд.....	8
6.2 Зарчмын нэр.....	9
6.3 Зарчмын мэдэгдэл.....	9
6.4 Зарчмын үндэслэл.....	9
6.5 Бусад зарчимтай харилцах	10
6.6 Үр нөлөө	10
6.7 Хүссэн үр дүн	10
6.8 Засаглалын зан төлөв.....	11
Ном зүй	13

Өмнөх үг

ОУСБ (Олон улсын стандартчиллын байгууллага) ба ОУЦТК (Олон улсын цахилгаан техникийн комисс) нь дэлхий даяар стандартчиллын тусгай тогтолцоог бүрдүүлдэг. ОУСБ болон ОУЦТК-ийн гишүүн үндэсний байгууллагууд нь техникийн үйл ажиллагааны тодорхой салбарыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагаас тодорхой чиглэлийн дагуу байгуулсан техникийн хороодоор дамжуулан олон улсын стандартыг боловсруулахад оролцдог. ОУСБ болон ОУЦТК-ийн техникийн хороод сонирхсон чиглэлээр хамтран ажилладаг. ОУСБ болон ОУЦТК-тай хамтран ажилладаг төрийн болон төрийн бус бусад олон улсын байгууллагууд уг ажилд оролцдог. МТ-ийн салбарт ОУСБ ба ОУЦТК нь хамтарсан техникийн хороо (ISO/IEC JTC 1) байгуулан ажиллаж байна.

Энэ баримт бичгийг боловсруулахад ашигласан болон цаашид дахин сайжрууж хянах журмыг ОУСБ/ОУЦТК-ийн Удирдамжийн 1-р хэсэгт тайлбарласан болно. Тухайлсан ялгаатай төрлийн баримт бичигт шаардагдах өөр өөр шалгуур үзүүлэлт шаардлагатайг тэмдэглэвэл зохино. Энэ баримт бичгийн төслийг ОУСБ/ОУЦТК Удирдамжийн 2-р хэсэгт дурдсан хянах засвар оруулах журмын дагуу боловсруулсан болно (www.iso.org/directives -ыг үзнэ үү).

Энэ баримт бичгийн зарим бүрдэл хэсэг нь патентын эрхэд хамаарч болзошгүйд анхаарал хандуулсан. ISO болон IEC нь патентын эрхийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн тодорхойлох талаар аливаа хариуцлага хүлээхгүй. Баримт бичгийг боловсруулах явцад илэрсэн аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл нь Танилцуулга хэсэг болон/эсвэл ОУСБ-ын хүлээн авсан патентын мэдүүлгийн жагсаалт (www.iso.org/patents) -д байна.

Баримт бичгийг боловсруулах явцад тодорхойлсон аливаа патентын эрхийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулга ба/эсвэл хүлээн авсан патентын мэдүүлгийн ISO жагсаалтад оруулна (www.iso.org/patents-ыг үзнэ үү).

Энэхүү баримт бичигт ашигласан аливаа худалдааны нэр нь хэрэглэгчид тохиромжтой байх зорилгоор оруулсан мэдээлэл бөгөөд мөрдүүлэх зорилгогүй.

Тохирлын үнэлгээнд хамаарах ОУСБ-ын онцлог нэр томъёо ба хэллэг болон Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаан дахь саад тотгорыг бууруулах тухай хэлэлцээрийн зарчмыг дагаж мөрдөхтэй холбоотой мэдээллийг дараах сайтаас үзнэ үү: www.iso.org/iso/foreword.html -ыг үзнэ үү.

Энэ стандартыг Олон улсын стандартчиллын байгууллага, Олон улсын цахилгаан техникийн комиссын хамтарсан техникийн хорооны МТ-ийн үйлчилгээний менежмент ба МТ-ийн засаглалын 40-р дэд хорооноос (ISO/IEC JTC 1/SC 40) боловсруулсан.

Энэ стандартыг Олон улсын цахилгаан техникийн комиссын Хөгжиж буй оронд зориулсан хөтөлбөрийн удирдагч Г.Батцэнгэл холбогдох хууль тогтоомж, стандартын нэр томъёонд нийцүүлэн орчуулж, Монгол Банкны МТ-ийн аудитор М.Саруул хянасан.

Танилцуулга

МТ-ийн засаглал, удирдлагын хүрээнд зарчимд суурилсан стандартыг дэмжихэд шаардлагатай мэдээлэл, зөвлөмж өгөх зорилгоор энэхүү баримт бичгийг боловсруулсан болно.

Зарчимд суурилсан стандартчиллын хандлага нь төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн байгууллага, ашгийн төлөө бус бүх байгууллага, жижгээс том хүртэлх бүх байгууллагад тэдгээрийн МТ-ийн ашиглалтын цар хүрээнээс нь үл хамааран, зааварчилгагүй арга зүйгээр хангана.

Зарчимд суурилсан стандартын давуу тал нь үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой арга зүй, бүтэц, үйл явц, арга техникийг заахгүйгээр зарчмуудыг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тодорхойлж чаддаг оршино.

Олон улсын стандартын салбарт МТ-ийн засаглалын арга зүйн тодорхойлолт нь ISO/IEC JTC 1/SC 40 дэд хорооны хүрээнд хамаардаг. Энэ хүрээнд ISO/IEC 38500, ISO/IEC TS 38501 болон ISO/IEC TR 38502 олон улсын стандартууд хэрэгжиж байна.

МТ-ийн засаглалын салбарт зарчимд суурилсан стандартуудыг хэрэглэсэн туршлагаас харахад, санал болгож буй зарчмууд болон зөвшилцөлд үндэслэснээс гарах үр дүнгийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох шаардлага үүссэн. Иймд зарчмуудын үндэслэл, тэдгээрийг хэрэгжүүлснээс хүлээгдэж буй засаглалын зан төлөв, гарах үр дүнг нарийн тодорхойлох шаардлагатай байна.

Цаашид шинээр боловсруулах стандартууд болон одоогийн стандартуудын шинэчилсэн найруулгад зарчмын тодорхойлолтын зохих хэлбэрүүдийг сонгож, тууштай хэрэгжүүлэхийн тулд зарчмыг тайлбарласан бүх нийтлэг үзүүлэлтүүдийг боловсруулах нь зүйтэй. Энэхүү баримт бичиг нь зарчимд суурилсан засаглалын стандартын ерөнхий зөвлөмж болон зарчмуудыг хэлбэр, агуулга, найруулгын түвшний талаас нь тайлбарыг агуулсан.

Энэхүү баримт бичгийн зорилтот хэрэглэгчид нь редакторууд, ажлын хэсгийн гишүүд, дахин хянагчид болон зарчимд суурилсан стандарт, техникийн тайланг боловсруулахад оролцогчид, түүнчлэн МТ-ийн засаглалын мэргэжилтнүүд юм. Түүнчлэн байгууллагын бодлого, стандартыг боловсруулж буй мэргэжилтнүүд хэрэглэж болно. Тэд энэхүү баримт бичигт дурдсан өөрсдийн төсөлд тохиромжтой бүрдлүүдийг сонговол зохино. Тохиромжтой бүрдлүүдийг сонгосны дараа энэ баримт бичгийн хэрэглэгчид энд заасан арга зүйн дагуу тууштай ашиглах нь зүйтэй.

MT-ийн засаглал — MT-ийн засаглалын зарчимд суурилсан стандартын арга зүй

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь MT-ийн засаглал, менежментийн салбарын зарчимд суурилсан стандартыг дэмжихэд шаардлагатай мэдээллийн талаар арга зүйгээр хангана.

Арга зүй нь ерөнхий зөвлөмж, бүрдэлүүдийн тодорхойлолт, тэдгээрийг боловсруулах зөвлөмжийг агуулсан. Энд тодорхой зарчмууд эсхүл бизнесийн зорилгод болон MT-ийг ашиглан бизнесийн үр дүнд хүрэхийн тэдгээрийг тодорхой арга зүйд нэгтгэх талаар тайлбарлаагүй болно.

2 Норматив эшлэл

Энэ баримт бичигт норматив эшлэл байхгүй болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичгийн зорилгод ISO/IEC 38500 болон ISO/IEC TR 38502 стандартад заасан нэр томъёо, тодорхойлолтуудыг хэрэглэнэ.

ISO болон IEC нь стандартчилалд ашиглах нэр томъёоны мэдээллийн санг дараах хаягаар ажиллуулдаг:

- IEC Electropedia: <https://www.electropedia.org/>
- ISO Онлайн хайлтын платформ: <https://www.iso.org/obp>

3.1

засаглалын зан төлөв

байгууллагын засаглалын тогтолцооны нэг хэсэг болох хувь хүмүүс болон бүлгүүдийн үйлдэл

4 MT-ийн засаглалын стандарт

4.1 MT-ийн засаглалын стандартын зорилго, чиглэл

Засаглалын стандарт нь байгууллагад мэдээллийн технологийг ашигласан бизнесийн үр дүнг удирдан чиглүүлэх, хянах тогтолцооны талаар арга зүйгээр хангана.

MT-ийн засаглалын стандартууд нь байгууллагын дотор эрх бүхий субектийн үүрэг, түүний менежерүүдтэй харилцах харилцаа, MT-ийн засаглалын тогтолцоонд юу шаардлагатай эсвэл энэ бүгдийн талаар арга зүйгээр хангана. MT-ийн засаглалын стандартууд нь байгууллагын доторх MT-ийн ашиглалтад бүхэлд нь эсвэл хэсэгчлэн чиглэж болно.

Арга зүй нь бизнесийн стратеги болон МТ-ийн стратегид нийцэж, агуулж болно. Түүнчлэн засаглалын зан төлөв, бодлого тодорхойлох, удирдлагын зан төлөв, бизнесийн зорилго, үр дүнгийн хоорондын уялдаа холбоог харгалзаж болно.

Ийм стандартын хэрэглэгчид нь байгууллагын эрх бүхий субектийн гишүүд, байгууллагын үйл ажиллагаанд өндөр түвшний хяналт тавих үүрэг бүхий гүйцэтгэх менежерүүд байна.

4.2 МТ-ийн засаглалын стандартын ерөнхий зөвлөмж

МТ-ийн засаглалын стандартууд

а) Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) зэрэг засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн үзэл баримтлалд тулгуурласан байх бөгөөд МТ-ийн засаглалыг байгууллагын засаглалын дэд хэсэг гэж тайлбарлах;

б) эрх бүхий субъект, гүйцэтгэх менежерүүд зэрэг зорилтот хэрэглэгчдэд уншихуйц боловсруулагдсан байх;

в) тэдний хамрах хүрээ, ялангуяа МТ-ийн дэд салбаруудыг хамарсан тохиолдолд тодорхой тайлбарласан байх;

г) зарчимд суурилсан байх;

д) ISO/IEC 38500-д тодорхойлсон МТ-ийн засаглалын Үнэлэх-Удирдан чиглүүлэх-Хянаж шинжлэх загварт нийцсэн байх;

е) ISO/IEC TR 38502 стандартад дурдсан эрх бүхий субъект болон менежерүүдийн хариуцлага, үүргийг заагласан байх;

ё) тодорхой зохион байгуулалтын бүтэц, үйл явцыг заахгүйгээр тууштай хэрэгжүүлэх боломжтой байх;

ж) өөрөөр заагаагүй бол бүх хэмжээ, бүх төрлийн байгууллагад хамаарах;

5 МТ-ийн засаглалын зарчимд суурилсан арга зүй

5.1 Зарчимд суурилсан стандартыг ашиглах

Зарчимд суурилсан стандартын давуу тал нь ийм стандарт нь тодорхой арга зүй, бүтэц, үйл явц, арга техникийг заахгүй бөгөөд зарчмуудыг хэрэгжүүлсний үнэ цэнэ, үр дүнг тодорхойлж чаддаг оршино. Ингэснээр цаашид тууштай хэрэглэх арга зүйг боловсруулах боломж бүрдэж, байгууллага өөрийн бүтэц, үйл явцын хүрээнд арга зүйг хэрэгжүүлэх уян хатан байдлыг бий болгоно.

5.2 Засаглалын тогтолцоо

Зарчимд суурилсан засаглалын стандарт нь эрх бүхий субъект (эсвэл төлөөллийн)-ийн үйл ажиллагаа болон засаглалын хүрээний доторх менежментийн үйл ажиллагааг хамарсан, тодорхой тогтсон засаглалын тогтолцоонд суурилна. Сайн засаглал нь удирдлагын зан төлөв болон засаглалын зарчмыг байгууллагад үр дүнтэй, төлөвшүүлэхийн тулд хянаж, арга зүйгээр хангана.

5.3 Зармуудын багц


Зарчимд суурилсан засаглалын стандарт нь засаглалын тогтолцооны үндэс суурь болох үндсэн үзэл баримтлал эсвэл заалтуудыг тодорхойлсон зарчмуудын багцууд болон зарчмуудыг батлах, хэрэгжүүлэх бусад арга зүйг агуулсан байна.

Үзэл баримтлал болон байгууллагын засаглалын тогтолцоонд тэдгээрийн үр дагаврыг тодорхой болгохын тулд зарчим тус бүрийг хангалттай нарийвчлан тусгана. Зарчмуудын аливаа харилцан хамаарал болон давхцлаас зайлсхийх талаар тусгана.

5.4 Зарчмын хэрэгжилт ба бизнесийн үр дүнгийн хоорондын хамаарал

МТ-ийн стандартад суурилсан засаглалын арга зүйн үндэс нь засаглалын зарчмуудын хэрэгжилт, бизнесийн үр дүнгийн хооронд хамаарал бий гэсэн хүлээлт юм. Засаглалын зарчмууд болон бизнесийн үр дүнгийн бодит хамаарал нь байгууллагуудын хооронд харилцан адилгүй бөгөөд засаглалын тогтолцоо, байгууллагын чадавхи, гадаад хүчин зүйлс нөлөөлнө.

Засаглалын зан төлөв, удирдлагын зан төлөв, МТ-ийн идэвхжүүлэгчид, бодлого, соёл зэрэг хүчин зүйлсийн учир шалтгааны холбоог ойлгож, бий болгоход туслах хүчин зүйлсийн жишээг 1-р зурагт эвлүүлэг дүрсүүдээр үзүүлэв. Энэ зураг нь тодорхой хүчин зүйлс эвлүүлэг дүрсүүдийн хамаарлыг харуулах зорилогогүй бөгөөд тухайн байгууллагад чухал байж болох бусад хүчин зүйлсийг нээлттэй үлдээв.



1-р зураг. Засаглалын зарчим болон бизнесийн үр дүнгийн хоорондын хамаарал

МТ-д засаглалыг нэвтрүүлэх эцсийн зорилго нь бизнесийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх, МТ-ийн тусламжтайгаар бизнесийн эерэг үр дүнд хүрэх явдал юм. МТ-ийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлснээр эрх бүхий субъект болон засаглалын

тогтолцоонд менежерүүдийн үйл ажиллагааг хамарсан засаглалын тогтолцоог бүрдүүлж, 1-р зурагт үзүүлсэн үр ашигтай бизнесийн үр дүнд хүрэхэд хүргэнэ.

Энэхүү баримт бичиг нь зарчимд суурилсан арга зүйгээр хангаж, МТ-ийн засаглал болон одоогийн засаглалыг үнэлэх, сайжруулахад тодорхой зарчмуудыг үндэслэн хэрэгжүүлсний шууд үр нөлөө буюу зохистой засаглалын зан төлөв болон үр дүнг дэлгэрэнгүй тодорхойлно.

Зарчимд суурилсан арга зүй нь холбогдох бүх зарчмууд болон тэдгээрийг тууштай, бүрэн хэрэгжүүлэх талаар арга зүйг агуулна. Зарчмуудын аль нэгийг бүрэн хэрэгжүүлэхгүй байх нь оновчтой бус үр дүнд хүргэж болзошгүй. Байгууллагын удирдлагууд зарчим тус бүрийг нухацтай авч үзэж, тэдгээрийг байгууллагын үндсэн соёлын хэсэг болгохыг дэмжвэл зохино.


Бизнесийн үр дүнг МТ-ийн засаглалын тодорхой зарчимтай шууд холбосон арга зүйг боловсруулахад хүндрэлтэй байж болно. Бизнесийн үр дүн нь ерөнхийдөө тухайн бизнес эсвэл салбаруудад харьцангуй өвөрмөц байдаг бөгөөд амжилттай хэрэгжихэд нөлөөлдөг бусад хүчин зүйлүүдэд байгууллагын чадавхи, өрсөлдөөн зэрэг гадаад хүчин зүйлүүд орно.

Харилцан хамаарлыг ерөнхий утгаар нь арга зүйн үндэс болгож болно. МТ-ийн засаглалын зарчмуудыг бий болгох, зарчимд тулгуурласан арга зүйгээр хангах, МТ-ийн засаглалыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулахдаа хүссэн засаглалын зан төлөв, МТ-той холбоотой хүссэн идэвхжүүлэгчид, зохион байгуулалтын бусад чухал хүчин зүйлүүд болон бизнесийн боломжит үр дүнгүүдийн хоорондын хамаарлыг аль болох өргөн хүрээнд ойлгож, тайлбарлана.

6 Засаглалын зарчим бүрт шаардлагатай мэдээлэл

6.1 Мэдээллийн бүрдэлүүд

Зарчим тус бүрийг дэмжих мэдээллийн бүрдлүүдийг 2-р зурагт үзүүлэв. Бүрдлүүдийн дараалал нь шаталсан биш бөгөөд боловсруулгч стандартыг боловсруулахдаа уншигдахуйц байхад анхаарна. Мэдээллийн бүрдэлүүдээс гадна стандартууд нь 4 ба 5-р зүйлд тодорхойлсон ерөнхий арга зүйг агуулсан байна.



2-р зураг. Зарчим тус бүрийн мэдээллийн бүрдэлүүд

6.2 Зарчмын нэр

Зарчим тус богино нэртэй байна. Нэр нь уг зарчимд тусгагдсан үндсэн ойлголтуудыг тодорхой илэрхийлэхээс гадна цээжлэхэд хялбар байвал зохино. МТ-ийн засаглал, менежментэд холбоотой бусад ойлголттой андуурагдахгүйн тулд зарчмын нэрийг анхааралтай сонгоно.

Дараахь зүйлийг анхаарна:

- а) Нэр нь богино байх (нэгээс гурван үг).
- б) Зарчмын нэр эсхүл мэдэгдэлд арга зүй эсвэл техникийн тодорхой үр дүнг дурдахгүй.

6.3 Зарчмын мэдэгдэл

Зарчимд агуулагдсан үндсэн дүрэм эсвэл заалтыг тодорхой тусгасан байна.

Дараахь зүйл хамаарна.

- а) Зарчмын мэдэгдэл нь бүх хэмжээ, төрлийн байгууллагад хамаарна.
- б) Зарчмын мэдэгдэл бүр хоёрдмол утгагүй байна.

6.4 Зарчмын үндэслэл

Бизнесийн үр дүнд хүрэхэд зарчим яагаад чухал тухай өндөр түвшний мэдэгдэл байвал зохино. Энэ нь уг зарчмыг баталснаар эрх бүхий субъект болон гүйцэтгэх удирдлага хэрхэн МТ-ийн тусламжтайгаар бизнесийн үр дүнд хэрхэн хүрэх

боломжоор хангахыг тайлбарлана. Энд хүссэн засаглалын зан төлөв, удирдлагын зан төлөвийн хоорондын хамаарал болон МТ-ийн **идэвхжүүлэгчид** хэрхэн хүлээгдэж буй эсвэл хүссэн бизнесийн үр дүнд хүрэхэд хэрхэн дэмжлэг үзүүлэхийг илэрхийлсэн байна.

6.5 Бусад зарчимтай харилцах

Зарчим тус бүрийн хувьд бусад зарчимтай хэрхэн харилцан хамаарах талаархи тайлбарлавал зохино. Хэрэв нэг зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь бусдаас нь хамаардаг бол энэ тухай дурдана. Хэрэв үр дүнд хүрэхэд нэг зарчим нь нөгөөгөөсөө илүү ач холбогдолтой эсвэл ач холбогдол багатай бол үүнийг онцлон дурдана.

6.6 Үр нөлөө

Зарчим тус бүрийн үр нөлөөг харуулсан мэдэгдэл байвал зохино. Мэдэгдэл бүр нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа/даалгавартаа МТ-ийн засаглалд зарчмыг хэрэглэх талаар эрх бүхий субъектэд зориулсан зөвлөмж тэдний хийх

Мэдэгдэл бүр нь МТ-ийн засаглалын үйл ажиллагаа/ажилдаа уг зарчмыг хэрэгжүүлэх гэж буй эрх бүхий субъектэд өгөх зөвлөмжийг онцолсон байна.

Зарчмыг хэрэгжүүлснээр бизнест үзүүлэх нөлөө, үр дагаврыг тодорхой тусгасан байна. Хэрэглэгч “Энэ нь эрх бүхий субъектэд хэрхэн нөлөөлөх вэ?” гэсэн асуултын хариултыг хялбархан олох боломжтой байвал зохино. Хэт хялбарчлах, үл тоомсорлох, нөлөөллийн давуу талыг шүүхгүй байх нь чухал. Зарим үр нөлөөг зөвхөн болзошгүй үр дагавар гэж тодорхойлох бөгөөд бүрэн дүн шинжилгээ хийхээс илүү таамаглал байж болно.

Үүнийг хэрхэн зохион байгуулах жишээ (шалгаагүй) дараах байдалтай байна.

Стратегийн зарчмыг хэрэгжүүлсний үр нөлөө нь дараах байдалтай байна.

- *Гүйцэтгэх менежерүүдтэй хамтран ажиллаж, зөвлөгөө авсан эрх бүхий субъект нь МТ-ийн ашиглалтаас үнэ цэнийг бий болгох стратегийг боловсруулахад манлайллаар хангана.*
- *Эрх бүхий субъект нь бизнесийн зорилгодоо хүрэх стратегийн үр нөлөө, учирч болох аливаа эрсдэлийг харгалзан МТ-ийн бизнесийн стратегийг батална.*
- *Эрх бүхий субъект нь МТ-ийн стратеги болон холбогдох аливаа бодлогыг хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд байгууллагын гадаад болон дотоод орчныг тогтмол хянаж, дүн шинжилгээ хийнэ.*
- *Эрх бүхий субъект нь байгууллагын зан төлөвийг чиглүүлэх бодлого боловсруулж байх ёстой.*
- *Эрх бүхий субъект нь тулгамдсан асуудал гарах үед зорилго, стратеги, бодлогыг тодорхой болгох, тайлбарлах механизмтай байна.*
- *— Эрх бүхий субъект нь МТ-ийн бизнесийн стратегийн нэг хэсэг болгон санал болгож буй аливаа томоохон өөрчлөлтөд бизнесийн бэлэн байдлыг ойлгож, байгууллагын дотор шаардлагатай өөрчлөлтийг хийх үүрэг амлалт, чадавхитай байна.*

6.7 Хүссэн үр дүн

Зарчим тус бүрийн хувьд хүссэн үр дүнгийн мэдэгдэлтэйээс байвал зохино. Мэдэгдэл бүр нь зохистой засаглалыг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй нэг буюу хэд

хэдэн үр дүнг илэрхийлнэ. Үүнийг хэрхэн зохион байгуулж болох тухай жишээ (шалгаагүй) дараах байдалтай байна.

Стратегийн зарчмыг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй болон хүссэн үр дүн нь:

- *Бизнесийн стратеги нь бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд технологийг хамгийн үр дүнтэй ашиглана.*
- *— Байгууллага нь бизнесийг дэмжих, тогтвортой байлгахад шаардагдах МТ-ийн чадавхитай байна.*

Бүх зарчмуудын үр дүнгийн нийлбэр байдал нь зарчимд суурилсан засаглалын тогтолцооны шалгууруудын талаар арга зүйгээр хангана.

Үр дүнгийн мэдэгдлийн бүтцэд дараахь зүйлс хамаарна.

а) Үр дүнгийн мэдэгдэл нь юунд хүрэх ёстойг тодорхой зааж, МТ-ийн засаглалын хэрэгжилтийг удирдан чиглүүлэх тул үр дүн бүрийг тодорхой бөгөөд товч томъёолно.

б) Үр дүн бүр нь эерэг, ажиглаж болохуйц (эсвэл баталгаажуулж болохуйц) бодит үр дүнгээр илэрхийлэгдвэл зохино.

в) Үр дүнгийн мэдэгдэл тус бүр нэг үр дүнг илэрхийлнэ. Иймд өгүүлбэрүүдийг холбохдоо "ба" эсвэл "ба/эсвэл" гэсэн үгийг ашиглахаас зайлсхийнэ. Ийм бүтэц нь олон үр дүнг илүү сайн илэрхийлдэг.

6.8 Засаглалын зан төлөв

Зарчим тус бүрийг баталснаар засаглалын зан төлөвийн тухай мэдэгдэл хийнэ.

Засаглалын зан төлөвийн тухай мэдэгдэл нь МТ-ийн засаглалын тогтолцооны хүссэн шинж чанаруудыг тайлбарлана. Энэхүү мэдэгдлийг байгууллагын засаглалын тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд удирдан чиглүүлэхэд ашиглаж болно.

Байгууллага, түүний удирдлагын бүтцээр засаглалын зан төлөв хэрхэн дамждаг талаар тодорхой байх ёстой. Арга зүй нь засаглалын байгууллага зарчмуудыг баталснаас үүдэн гарах зан үйлийг менежерүүд хэрхэн хэрэгжүүлж, харуулахыг тайлбарлана.

Үүнийг хэрхэн зохион байгуулж болох тухай жишээ (шалгаагүй) дараах байдалтай байна.

Стратегийн зарчмыг баталснаар хүссэн зан төлөв нь дараах байдалтай байна.

- **Стратегийн шийдвэр гаргах.** МТ-ийн бизнесийн стратегийн талаархи шийдвэрийг байгууллагын зохих түвшинд нарийн дүн шинжилгээ, зөвлөгөөнд үндэслэн гаргадаг.
- **Мэдээллийн стратеги.** Мэдээллийн стратегийн давуу талыг хүлээн зөвшөөрч, төлөвлөдөг.
- **Стратегийн эрсдэл.** Технологид тулгуурласнаар тухайн байгууллагад учирч болох эрсдэлийг тодорхойлж, удирддаг.
- **Нийцэл.** МТ-ийн стратеги, архитектур, бодлого нь шинэ эсвэл өөрчлөгдсөн МТ-ийн чадавхийг хүргэх бизнесийн байнгын шаардлагыг дэмждэг.

- **Чадавхи.** Шаардлагатай чадавхийг ойлгож, төлөвлөдөг.
- **Хэрэглэгчтэй харилцах.** Хэрэглэгчийн МТ-ийн хэрэглээг дэмжих стратегийн тодорхой хандлагатай.

Дараахь зүйлс хамаарна.

- а) Засаглалын зан төлөвийн мэдэгдэл тус бүр нь богино нэр, тайлбарыг агуулсан байна.
- б) Хүссэн засаглалын зан төлөв болон МТ-ийн оновчтой засаглалыг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн хооронд тодорхой хамаарал байвал зохино.
- в) Зарчимд хамаарах хүссэн засаглалын зан төлөв нь үр дүнгийн мэдэгдэлд дурдсан зарчмын хүлээгдэж буй болон хүссэн үр дүнд хүрэхэд зайлшгүй бөгөөд хангалттай байвал зохино.
- г) Хүссэн засаглалын зан төлөвийн тухай мэдэгдлийг хэрэглээний аливаа хүрээ, өөрөөр хэлбэл, ямар ч салбар, аливаа хэмжээ бүхий байгууллагуудад хэрэглэхэдүйц утга агуулгатай бичнэ. Иймд энэ нь тодорхой техник, аргачлал шаарддаггүй. Тухайлбал, “Байгууллага доторх МТ-ийн хангамж, ашиглалтад тавих хяналтын механизмыг тодорхой тодорхойлсон байна” гэсэн мэдэгдэл нь “МТ-ийн эрх бүхий субъект байх ёстой” гэхээсээ илүү зөв засаглалын зан төлөв бөгөөд хүссэн засаглалын зан төлөвийг хэрэгжүүлэх жишээ, “МТ-ийн эрх бүхий субъект” байж болно.
- д) Засаглалын зан төлөв нь тодорхой үйл явц байгаа эсэхээс илүү практикт хамаарна. Ихэнх тохиолдолд жижиг байгууллагуудад нарийвчилсан үйл явц шаардлагагүй.
- е) Зан төлөвийн мэдэгдэл тус бүр нэг үр дүнг илэрхийлнэ. Иймд өгүүлбэрүүдийг холбохдоо "ба" эсвэл "ба/эсвэл" гэсэн үгийг хэрэглэхээс зайлсхийнэ. Ийм бүтэц нь олон мэдэгдлийг илүү илэрхийлдэг.

Ном зүй

- [1] ISO/IEC 38500, *Information technology — Governance of IT for the organization*
- [2] ISO/IEC TS 38501, *Information technology — Governance of IT — Implementation guide*
- [3] ISO/IEC TR 38502, *Information technology — Governance of IT — Framework and model*